



**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 26-35-06, Факс: (976-11) 31-81-69,
<http://www.mmhi.gov.mn>

2020.01.10 № 03/80

танай _____-ны № _____-т

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗАРТ**

Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоолын дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газарт иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн 2019 оны жилийн эцсийн тайлан, мэдээг хүргүүлж байна.

Хавсралт 4 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА  Т.НАНДИНЖАРГАЛ



СЗ 0057

| Д/УУХҮЯ Яам А5

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны
 2020 оны...01...сарын...10...өдрийн
 03/80...албан бичгийн хавсралт

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ,
 ЯАМНЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГА АШИГТ МАЛТМАЛ,
 ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАРТ ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА,
 АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН
 ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН
 /2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР/

ХҮСНЭГТ №1

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт %
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтэрсэн	Хугацаа болоогүй	
1	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	293	290	-	3	6	98,9%
2	Ашигт малтмал, газрын тосны газар	590	590	-	-	4	98,9%
НИЙТ		883	880	-	3	10	99,4%

2019 ОНД ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА,
 АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ
 ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТ /хэлбэрээр/

ХҮСНЭГТ №2

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Үүнээс:				
			Бичгээр	Цахимаар	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
1	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	293	293	-	-	-	-
2	Ашигт малтмал, газрын тосны газар	590	590	-	-	-	-
НИЙТ		883	883	-	-	-	-

ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД
ГАРГАСАН ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТИЙН АГУУЛГА,

ХҮСНЭГТ №3

№	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал тоо /нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь
1	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	Нийт 883 өргөдлөөс: <ul style="list-style-type: none"> • Хүсэлт - 551 буюу 62,4% • Гомдол - 314 буюу 35,5% • Санал – 18 буюу 2% Агуулгаар нь ангилвал: <ol style="list-style-type: none"> 1. Хүний нөөцийн асуудлаар -315 буюу 35,6% 2. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар -293 буюу 33,1% 3. Тусламж, дэмжлэг хүссэн – 102 буюу 11,5% 4. Лавлагаа -94 буюу 10,6% 5. Түлш, газрын тосны асуудлаар- 17 буюу 1,9% 6. Геологи, уул уурхайтай холбоотой асуудлаар -15 буюу 1,6% 7. Сонгон шалгаруулалттай холбоотой асуудлаар – 13 буюу 1,4% 8. Бусад- 34 буюу 3,8%. Үүнээс: <ul style="list-style-type: none"> • Салбарын шагналын тэмдэг дахин олгох -20 буюу • 1072 хувьцаатай холбоотой асуудлаар - 7 буюу 2,3% • Нийгмийн даатгалтай холбоотой асуудлаар - 5 буюу 1,7% • Хөрөнгө оруулалттай холбоотой асуудлаар – 2 буюу 0,6%
2	Ашигт малтмал, газрын тосны газар	

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах талаар зохион байгуулсан ажил, арга хэмжээ

1. Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн, шуурхай хүргэх үүднээс иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, хариутай бичгийг цал алдалгүй иргэнд хариуг уламжлах хариуцлага, хяналтыг сайжруулах зорилгоор яамны удирдлагууд болон албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод уг асуудлыг заалт болгон нэмж тусгуулсан.
2. 14 хоног тутамд яамны нийт албан хаагчид оролцдог “Мэдээллийн цаг”-аар иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явц, байдлыг газар, нэгж тус бүрээр нарийвчлан гаргаж танилцуулан Төрийн захиргааны удирдлагын газрын дарга газар, нэгжийн удирдлага, албан хаагчдад төрөөс иргэдэд үзүүлж буй үйлчилгээг түргэн, шуурхай хүргэж ажиллах талаар тодорхой чиглэл өгч, удирдлагуудыг хяналт тавин ажиллах талаар үүрэг өгөв.
3. Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/149 дүгээр тушаалаар Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газраас өгсөн чиглэл, хуваарийн дагуу Засгийн газрын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулж иргэдээс Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эрхлэх асуудлын хүрээнд нийт 26 үүнээс 10 өргөдөл, 11 хүсэлт, 5 санал ирүүлж, 14 өргөдлийн хариуг албан бичгээр хүргүүлж 11 өргөдлийн хариуг амаар уламжлав.
4. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Авилгатай тэмцэх газар, Азийн сангаас хамтран 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулсан “Төрийн байгууллагуудын өргөдөл, гомдол хариуцсан ажилтнуудыг чадавхижуулах сургалт”-аар төр, захиргааны байгууллагууд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцын мэдээлэл хийхэд Ашигт малтмал, газрын тосны газар нь 2019 онд нийт 66 өргөдөлд 104.12 дундаж хоногийн хугацаанд хамгийн удаан хариу өгсөн байгууллагын жагсаалтад орсон ба Ашигт малтмал, газрын тосны газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргад тус яамны зүгээс өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хатуу анхаарч, уг алдаа дутагдлыг дахин давтаж ажиллахгүй байх талаар үүрэг, чиглэл өгсөн.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ,
ЯАМНЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГА АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАРТ ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА,
АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

2020 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоол болон холбогдох хууль тогтоомжийн дагуу иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг бүртгэн авч, судалж шийдвэрлэн хуулийн хугацаанд хариу өгч ажиллав.

Тус яаманд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын агуулга, шийдвэрлэлтэд тогтмол хяналт тавьж, тайлан мэдээг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулан хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд тогтмол хяналт тавин, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцын мэдээ, тайланг 14 хоног тутам Төрийн захиргааны удирдлагын газрын даргад танилцуулан ажиллаж байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Ашигт малтмал, газрын тосны газарт 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 883 өргөдөл, гомдол албан бичгээр ирсэн байна. Эдгээрээс хариуг шийдвэрлэж албан бичгээр өгсөн 880, үүнээс хугацаа болоогүй 10, хугацаа хэтэрсэн 3 өргөдөл ба шийдвэрлэлт 99,4%-тай байна.

Иргэдээс хандаж ирсэн 883 өргөдөл, гомдол, санал хүсэлтээс хүний нөөцийн асуудлаар -315 буюу 35,6%, тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар -293 буюу 33,1%, тусламж, дэмжлэг хүссэн – 102 буюу 11,5%, лавлагаа -94 буюу 10,6%, түлш, газрын тосны асуудлаар- 17 буюу 1,9%, геологи, уул уурхайтай холбоотой асуудлаар -15 буюу 1,6%, сонгон шалгаруулалттай холбоотой асуудлаар – 13 буюу 1,4%, бусад асуудлаар - 34 буюу 3,8% байна.

Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 3 өргөдлийн агуулгыг судлан үзэхэд тус яамны эрхлэх асуудлын хүрээнд шууд шийдвэрлэх, хариуг өгөх боломжгүй, холбогдох газрын шийдвэр, хариуг хүлээх зэргээс шалтгаалж удааширсан байна. 2019 оны жилийн эцсийн байдлаар өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцын тэмдэглэлийг тогтмол хөтөлж хэвшсэн үзүүлэлттэй байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 13 дугаар хуралдаанаар 2019 онд тус яаманд иргэдээс хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээг танилцуулж, хуралдааны тэмдэглэлийг яам, агентлагийн газар, нэгжийн дарга, албан хаагчдад танилцуулан сайдын зөвлөлөөс өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж сар бүрийн сүүлийн 7 хоногт тайлан, мэдээг Төрийн захиргааны удирдлагын газарт ирүүлж ажиллах талаар чиглэл, заавар өгөв.



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН
САЙДЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 01 сарын 06 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ,
АГЕНТЛАГИЙН ДАРГА, АЛБАН ХААГЧ НАРТ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 13 дугаар хуралдааны тэмдэглэлд:

2019 жилийн эцсийн байдлаар иргэдээс Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон харьяа байгууллага Ашигт малтмал, газрын тосны газрын албан тушаалтанд иргэдээс хандаж ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаар Төрийн захиргааны удирдлагын газрын дарга М.Баяраа сайдын зөвлөлийн гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг яам, агентлагийн удирдлага, албан хаагчдад үүрэг болгов:

1. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд цаг алдалгүй шийдвэрлэх;
2. Өргөдөл нь тус яамны эрхлэх асуудлын хүрээнд шууд шийдвэрлэх боломжгүй, холбогдох газрын шийдвэр, хариуг хүлээх зэргээс шалтгаалж байгаа тохиолдолд шийдвэрлэлтийн явцыг тэмдэглэх эсхүл иргэн, аж ахуйн нэгжид өргөдлийн шийдвэрлэлтийн явцын талаар утсаар болон цахимаар мэдээлэх;
3. Иргэнээс хандсан өргөдлийг хуулийн хугацаанд яамны эрхлэх асуудлын хүрээнд шийдвэрлэх боломжгүй тохиолдолд харьяалах газар, нэгжийн даргад танилцуулан, Төрийн захиргааны удирдлагын газрын даргын зөвшөөрлөөр хуульд зааснаар сунгалтыг хийх". гэжээ.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЗӨВЛӨЛ



08 0033